

**МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЧЛОЛ**

2013.01.25

№ 1

Улаанбаатар хот

Хурлыг 2013 оны 1 дүгээр сарын 25-нд Монголбанкны Ерөнхийлөгч Н.Золжаргал удирдан хуралдуулав.

Бодлогын шийдвэр гарахын өмнө Мөнгөний бодлогын зөвлөл (МБЗ) макро эдийн засгийн өнөөгийн болон ойрын ирээдүйн төлвийн талаарх дараах асуудлуудыг авч хэлэлцлээ.

Монгол Улсын экспорт 9 хувиар, гадаадын шууд хөрөнгө оруулалт 17.0 хувиар буурсан нь эдийн засгийн гадаад орчин сул байгааг харуулж байна. Төсвийн 2013 оны төлөвлөгөөнд төсвийн орлого 2012 оны гүйцэтгэлээс 46.6 хувиар, зардал 25.6 хувиар нэмэгдэхээр төсөөлжээ. Төсвийн зардал дотор хөрөнгийн зардал нэмэгдсэн ч, урсгал зардлын ДНБ-д эзлэх хэмжээ буурсан нь инфляцийн дарамтыг бууруулах болно.

Гадаад эрэлт 2012 онд сул байснаас мөнгөний нийлүүлэлтийн өсөлт саарч 18.8 хувьд, зээлийн өсөлт удааширч 23.9 хувьд хүрсэн нь сүүлийн жилүүдийн дунджаас бага үзүүлэлт байлаа. Дэлхийн эдийн засгийн төлөв 2013 онд хангалттай сайжрахааргүй, мөнгөний нийлүүлэлт гадаад эх үүсвэрээр бус дотоод эх үүсвэрээр голлон нэмэгдэж, өсөлт нь 2012 оны түвшинд байхаар хүлээгдэж байна.

Улаанбаатар хотын 2012 оны жилийн инфляцийн 33.4 хувийг махны үнийн өсөлт бүрдүүлж байлаа. Монголбанкны 2013 он 1 дүгээр сард тооцсон суурь төсөөлөлд инфляци 2013 оны эцэст 7.1 хувь байхаар төсөөлөгдөж байна. Энэхүү суурь төсөөлөл нь мөнгөний бодлогын өнөөгийн (бодлогын шийдвэр гарахаас өмнөх үеийн) төлөв өөрчлөгдөхгүй, төсвийн зарцуулалт 2013 оны батлагдсан хэмжээгээр хийгдэнэ, төсвийн тэнцлээс гадуур хөрөнгө оруулалт хийгдэхгүй, инфляцид нийлүүлэлтийн шалтгаантай дарамт үүсэхгүй, үнийг тогтворжуулах чиглэлээр Монголбанк, Засгийн газрын хамтарсан хөтөлбөрүүд амжилттай хэрэгжиж, төрийн зохицуулалттай үнэ өсөх дарамт бий болохгүй зэрэг нөхцлүүдэд тус тус үндэслэгдсэн.

Эдийн засгийн дээрх нөхцөл байдлыг үндэслэн, инфляци зорилтот түвшинг хангахаар хүлээгдэж байгаа үед эдийн засаг дахь хувийн секторын оролцоог нэмэгдүүлэх, урт хугацаанд тогтвортой өсөлтийг хангах хувийн хөрөнгө оруулалтыг урамшуулах үүднээс Монголбанкны бодлогын хүүг 1.25 нэгж хувиар бууруулж, 12.0 хувь болгох саналыг хэлэлцэв.

БОДЛОГЫН ШИЙДВЭР

МБЗ-ийн ажиллах журмын дагуу Монголбанкны Ерөнхийлөгч мөнгөний бодлогын саналыг шүүмжлэх болон хамгаалах багийг томилсон болно.

Бодлогын саналтай холбоотой хэд хэдэн асуудлаар шүүмжлэх баг байр сууриа илэрхийлсэн бол хамгаалах баг асуултад хариулах, холбогдох тайлбарыг хийх байдлаар хэлэлцүүлэг өрнөлөө.

Шүүмжлэх баг юуны түрүүнд 2013 онд “Оюу толгой” уурхайн олборлолт эхлэхтэй уялдан ДНБ-ий өсөлт өндөр гарахаар хүлээгдэж байгаа нь эдийн засаг хөрөөгүй, харин ч халж болохыг харуулж байна, бодлогын саналд дурдсанчлан инфляцийн дарамт нэмэгдэхээргүй байна гэснийг шүүмжиллээ. Тухайлбал, бодит ДНБ-ий өсөлтөөр эдийн засгийн идэвхжлийг хэмжихэд хангалттай бус, өсөлт нь уул уурхайн салбараас голлон шалтгаалахаар байна. Уг салбарын өсөлт нь эдийн засгийн бусад салбаруудад хүртээмж багатай гэсэн тайлбар хийлээ. Потенциал ДНБ өсөх бөгөөд үүнийг давж нийт эрэлт нэмэгдэхгүй, бодит болон потенциал ДНБ-ий өсөлтийн зөрүүгээр хэмжигдэх үйлдвэрлэлийн зөрүүг тооцоход эдийн засгийн халалттай онуудад эерэг утгатай, харин 2012 оноос эхлэн буурч 2013 онд бага зэрэг сөрөг утгатай болсон нь бодит эдийн засгийн инфляцид үзүүлэх дарамт бага байна гэсэн үндэслэлүүдийг тус тус хэлэлцэв.

Шүүмжлэх баг 2013 онд Засгийн газар, Монголбанкны хамтарсан хөтөлбөр, Засгийн газар, Хөгжлийн банкны бондын нөлөөгөөр мөнгөний нийлүүлэлт нэмэгдэхээр байхад бодлогын хүүг бууруулах нь эртэдсэн арга биш үү гэдгийг тодруулав. Үүнд хамгаалах багийн зүгээс дээрх нөлөөллийг тусгаснаар 2013 онд мөнгөний нийлүүлэлт 2012 онтой ойролцоо түвшинд өсөхөөр хүлээгдэж байна. Ингэхдээ дотоод эх үүсвэр буюу дотоод цэвэр активын өсөлтөөр мөнгөний нийлүүлэлт өснө гэж таамаглаж байгаа. Нөгөө талаас гадаад эрэлт сул байгаа учир гадаад эх үүсвэрээр мөнгөний нийлүүлэлт өсөхөөргүй байна. 2013 онд төсвийн их хэмжээний хөрөнгө оруулалт хийнэ. Мөн мөнгөний үзүүлэлтүүдийн өсөлт олон жилийн дунджаас бага, мөнгөний бодлогын төлөв чанга талдаа байгаа зэрэг нь хувийн хэвшилд хөрөнгө оруулалтын боломжийг нэмэгдүүлэхгүй байна. Иймд бодлогын хүүг бууруулах нь хувийн секторыг дэмжих, эрэлтийг нэмэгдүүлэх ач холбогдолтой гэсэн тайлбар өглөө.

Үүний дараа шүүмжлэх багаас бодлогын хүүг яагаад заавал 1.25 нэгж хувиар буулгах саналтай талаар тайлбар авахыг хүслээ. Үүнд хамгаалах багаас бодлогын хүүний өөрчлөлт нь мөнгөний бодлого аль чиглэлд өөрчлөгдөж буйг илтгэнэ. Олон улсын туршлагаас харахад бодлогын хүүний түвшин өндөр бол хүүний өөрчлөлтийн бүтэн алхам нь 1 нэгж хувь, хагас алхам нь 0.5 нэгж хувь байдаг, тиймээс 1 хувь бол эхний алхам, харин үлдсэн 0.25 хувь нь 2008 оны 9.75-ын бутархай хувийг цэвэрлэж байгаа юм гэсэн тайлбарыг өглөө.

Шүүмжлэх баг цааш нь инфляци 14 хувьтай байгаа нь эдийн засаг хөрөөгүй, харин ч халалттай байгааг харуулж байгаа бус уу гэсэн асуулт тавив. Бодлогын хүү нь тодорхой хугацааны дараа инфляцид нөлөөлдөг. Иймд бодлогын хүүг өөрчлөх шийдвэрийг 2012 оны инфляцид бус харин түүний ирээдүйн төсөөлөлд үндэслэн гаргадаг гэсэн хариуг хамгаалах багийн зүгээс өглөө.

Ийнхүү Мөнгөний бодлогын зөвлөлийн гишүүд хүүг бууруулах саналыг тал бүрээс нь нухацтай авч үзэн, өргөн хүрээнд хэлэлцүүлэг хийсний дүнд, инфляцийн хэтийн хандлага зорилтот түвшинтэй нийцтэй байна, эрэлтийн болон нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамт багасахаар хүлээгдэж байгаа нь бодлогын хүүг бууруулах нөхцлийг бүрдүүлж байна гэсэн байр суурьт санал нэгдлээ. Улмаар бодлогын хүүг бууруулах эсэх дээр санал хураахад МБЗ-ийн дийлэнх олонх гишүүн дэмжлээ.

Ингэхдээ МБЗ-өөс бодлогын хүүг болгоомжтой, нөхцөл байдлыг тал бүрээс нь анхааралтай судлан үзсэний үндсэн дээр бууруулж байгааг зөвлөлийн гишүүд онцоллоо. Үүний дараа бодлогын хүүг 1 нэгж хувиас их хувиар бууруулах талаар санал хураахад 3 гишүүн дэмжиж, 4 гишүүн эсрэг саналтай байснаар бодлогын хүүг 1 нэгж хувиас бага хувиар бууруулах санал дэмжигдэв.

Бодлогын хүүг бууруулсанаар мөнгө, зээлийн өсөлтийг тогтворжуулан, санхүүгийн салбарын хэвийн үйл ажиллагааг хангаж, эдийн засгийн идэвхжлийг дэмжих боломжийг олгож буй хэдий ч, цаашид гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын орчны тодорхой бус байдлыг анхааралтай ажиглах нь зүйтэй гэдэгт зөвлөлийн гишүүд санал нэгдсэнээр МБЗ-ийн анхдугаар хурал өндөрлөв.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөлийн 2013 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн хурлаар Бодлогын хүүг 0.75 нэгж хувиар бууруулан, 12.5 хувь болгох шийдвэр гаргав.